



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№237 /446/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.02

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ТАНГАРАГ ДАВТЛАА



Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 111 жилийн ойг тохиолдуулан XII ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн цэргийн тангараг давтлаа.

Энэ үеэр цэргийн багийн удирдлага 2023 онд хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, бодлогоо бие бүрэлдэхүүнд танилцуулан, үүрэг, чиглэл өгсний зэрэгцээ БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ҮБХИС-ийн сургалтын төвийн цэргийн биеийн тамир

цэрэгжлийн спортын ахлах багш хошууч Б.Батдэмбэрэлд албан тушаалын зэрэглэлийн дэд хурандаа цол олгогдсоныг гардуулан өгсөн юм.

Мөн мандатаар хүлээсэн үүргээ мадаггүй сайн биелүүлж, хамт олноо манлайлан идэвх санаачилгатай ажиллаж байгаа зарим цэргийн алба хаагчдыг батальоны захирагчийн тушаалаар сайшаан, анги байгууллагууд руу нь талархлын захидал илгээлээ.

Ахлахдэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-17	-29

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.465	3.477
EUR	3.715	3.740
CNY	498	501
RUB	47.20	48.60
JPY	26.00	26.40
KRW	2.73	2.76

ЭЦЭГ ЭХДЭЭ МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЖ, УРГАХ НАРЫГ УГТЖЭЭ



Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хугацаат цэргийн алба хаагчдынхаа шинэ жилийн баярыг ёслол төгөлдөр тэмдэглэхийн зэрэгцээ аав, ээж, гэр бүлийнхэндээ мэндчилгээ дэвшүүлэх боллоцоог нь бүрэн хангажээ.

Дайчид гэрийнхэнтэйгээ захидлаар болон цахимаар холбогдож, шинэ оны мэнд дэвшүүлж, шинэ жилийнхээ баярын сонин сайхныг хуваалцсан байна. Мөн зарим нэгтгэл, ангийнхан 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өглөө хугацаат алба хаагчидтайгаа хамт ургах нарыг угтсан байна.



БАЙЛДАГЧИЙН ААВ ӨВЛИЙН ӨВӨӨ БОЛЖ, БЭЛЭГ БАРИВ



Зэвсэгт хүчний 014, 120, 256 дугаар ангийнхан хугацаат цэргийн алба хаагчдынхаа "Жаргалтай шинэ жил" баярын арга хэмжээг зохион байгууллаа.

Тэд хугацаат цэргийн алба хаагчдадаа олон гэнэтийн бэлгүүд задалсан бөгөөд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийнхан гэхэд байлдагч Г.Заяамандахын аав Л.Ганбаатарыг өвлийн өвөөгийн дүрээр шинэ жилийн баяртаа урьж оролцуулав.

Л.Ганбаатар дайчдад бэлэг гардуулсны дараа "Ах нь 1984 онд хугацаат цэргийн алба хааж байснаас хойш 40 орчим жил өнгөрчээ. Цэргийн орчин, цог жавхаатай та бүхэн миний залуу насыг санагдууллаа. Цэргийн алба нь өөртөө итгэх итгэлийг олгож, амьдралын ухаанд сургадаг хосгүй сургалт" гээд албаа нэр төртэй хаахыг аавын ёсоор захиж байна

Зэвсэгт хүчний 120 дугаар ангийнхны хувьд хугацаат албаны дайчдын баяраа ёслол төгөлдөр тэмдэглэсэн ба энэ өдөр ангийн захирагч асан, бэлтгэн хурандаа Б.Цагаан 5 дахь жилдээ өвлийн өвөө болж, бэлэг тараасан юм. Шинэ жилийн баярыг угтан хэд хэдэн уралдаан зарласнаас "Шилдэг ханын сонин"-той салбараар ахлах дэслэгч Б.Базаррагчаа захирагчтай батарей, "Шилдэг мэндчилгээ"-тэй салбараар ахмад Б.Ууганбаяр захирагчтай батарейны хамт олон тус тус шалгарав.

Харин Зэвсэгт хүчний 256 дугаар ангийнхан "Жаргалтай шинэ жил"-ээр тэргүүний байлдагчаар Б.Эрболдыг тодруулсан бол офицер, ахлагч нарын зүгээс дайчдадаа гарын бэлэг гардуулж хуучин оноо үдэж, шинэ оноо угтжээ.

ДАЙЧИД ШИНЭ ЖИЛИЙН ҮДШЭЭР...




Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хугацаат цэргийн алба хаагчдынхаа шинэ жилийн баярыг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлжээ.

Энэхүү арга хэмжээ нь уламжлал болсон бөгөөд дайчдад албаараа бахархах, сэтгэл санааг нь өргөх, хамт олонч уур амьсгалыг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй юм.

Хошууч генерал Ч.Самбуугийн нэрэмжит Алтангадас одонт Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийнхан дайчдынхаа "Мөнгөн өвөл" шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулжээ.

Ёслолын арга хэмжээнд Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн бүжгийн хамтлаг болон цэргийнхэндээ "Марш тактик", "Онжав, "Хал цэргийн дуу"-гаараа танигдсан реппер, ахлах ахлагч Ш.Даваацэрэн (084) нар хүрэлцэн ирж ая дуугаа өргөж, химичин дайчид дуу хуур, бүжиг наадамтай нэгэн өдрийг өнгөрүүлэв.

Химичин дайчдаас "Манлайлагч байлдагч"-аар байлдагч А.Баярцогт, "Шинийг санаачлагч байлдагч"-аар Б.Отгонцагаан нар шалгарчээ.



ЗУРХАЙ

2022.01.02 / ДАВАА ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 11

ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ЦАГААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал: Эрхтэн хурц болно Наран ургах, шингэх: 08.42-17.10 Барилдлага: Үхэх Шүтэн барилдлага: Авахуй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 665,209,964

Эдгэрсэн

Нийт: 637,065,102

Нас барсан

Нийт: 6,697,922

Цахим шууданд

ОНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



БНМАУ-ын маршал Г.Дэмидийн нэрэмжит, Байлдааны гавьяаны Улаан тугийн болон Алтангадас одонт Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн бие бүрэлдэхүүн энэ сарын 30-ны өдөр 2022 оны амжилт бүтээлээ тодотгож, Цэргийн тангараг давтах ёслолыг зохион байгуулав.

Энэхүү ерөөл хишиг бүрдсэн өдөр Мотобуудлагын батальоны соёл хүмүүжлийн зааварлагч Б.Номинжингоод ЗХЖШ-ын даргын тушаалаар дэслэгч цол олгосныг ангийн удирдах албан тушаалтнууд гардуулан өгөхийн зэрэгцээ цэргийн албанаас бэлтгэлээр чөлөөлөгдөж байгаа алба хаагчид ангийн Байлдааны тугандаа хүндэтгэл үзүүлсэн юм.

Мөн тус ангийнхан цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдынхаа "Жаргалтай шинэ жил" арга хэмжээг цасан охин, өвлийн өвгөний хамт тэмдэглэж баяр хөөр бялхсан өдрийг дурсамж дүүрэн

өнгөрүүлэв.

Үргэлжлүүлэн ангийн 2021-2022 оны сургуулийн жилд бүтээлч хандлага, цэргийн алба, сахилга хариуцлагаараа бусдыгаа манлайлсан бүрэлдэхүүнийг шалгаруулж, шагнаж урамшууллаа.

"Тэргүүний офицер"-оор Мотобуудлагын батальоны захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга ахмад Х.Анхбаяр, "Тэргүүний ахлагч"-аар Цацраг хими, биологиос хамгаалах экологийн албаны ахлагч Л.Батдорж, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар гэрээт харуулчин Л.Эрдэнэхүү, "Тэргүүний салааны захирагч"-аар Мотобуудлагын батальоны салааны захирагч дэслэгч М.Билгүүн, "Тэргүүний хамт олон"-оор хошууч Ц.Жүгдэррэнцэн даргатай Орон сууцны алба, "Тэргүүний бүтээлч хамт олон"-оор Б.Нармандах даргатай Гэрээт харуулын албаны хамт олон тус тус шалгарсан юм.

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 110 ДУГААР АНГИ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 350 ДУГААР АНГИ



маркетингийн тасгийн эдийн засагч Ц.Цолмон, "Тэргүүний барилгачин"-аар барилгын материал үйлдвэрлэлийн ротын хөрөө рамчин-хийц бэлтгэгч ахлагч Т.Даш-Амар, "Тэргүүний хугацаат цэргийн алба хаагч"-аар инженер сапёрын ротын 1 дүгээр салааны байлдагч Б.Амарзаяа, "Тэргүүний жагсаалч байлдагч"-аар инженер сапёрын ротын 2 дугаар салааны байлдагч Б.Дашдагва, "Манлайлагч байлдагч"-аар инженер сапёрын ротын 3 дугаар салааны байлдагч З.Бат-Орших, "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар барилгын материал үйлдвэрлэлийн ротын бетон хийцийн тасгийн блокчин байлдагч Ш.Эрдэнэ-Очир нар тус тус шалгарч хамт олноо манлайлсан юм.

Ахмад Т.МӨНХ-ЭРДЭНЭ



Зэвсэгт хүчний 350 дугаар анги 2022 оны үйл ажиллагааны тайлангаа дүгнэж, баярын хурлаа хийж ажил үйлсээрээ манлайлсан ажилтан, алба хаагчдаа тодрууллаа.

"Хөдөлмөрийн аварга офицер"-оор ахлахдэслэгч Б.Баасанцэрэн, "Хөдөлмөрийн аварга удирдах ахлагч"-аар сургагч ахлагч М.Батмөнх, "Хөдөлмөрийн аварга гүйцэтгэгч ахлагч"-аар ахлагч Д.Даваасүрэн, "Тэргүүний энхийг сахиулагч"-аар ахлах ахлагч М.Мэндбаяр, "Хөдөлмөрийн аварга

ажилтан"-аар Л.Лхагвадулам, "Тэргүүний тамирчин"-аар ахлах ахлагч Б.Балжинням, дэд ахлагч Г.Бодъяргал нар шалгарав. Мөн "Тэргүүний салбар"-аар нэгдүгээр мотоуудлагын рот, "Тэргүүний хамт олон"-оор цэргийн гал тогоо, "ТХЦК-ийн хүндэт өргөмжлөл"-өөр тус ангийн орон сууцны байцаагч Л.Лхагвадулам нар шалгарч ангийн захирагч хурандаа Ж.Сүх-Очир, ТХЦК-ийн тусгай ажиллагааны газрын дарга хурандаа н.Болдбаатар нараас шагналаа гардан авлаа.

Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 110 дугаар анги оны тэргүүний хамт олон, цэргийн алба хаагчдаа шалгаруулан шагнаж урамшууллаа.

"Тэргүүний хамт олон"-оор Барилгын материал үйлдвэрлэлийн рот, "Тэргүүний алба"-аар зэвсэг, техникийн алба, "Тэргүүний офицер"-оор үйлдвэрлэл маркетингийн тасгийн технологич, чанарын инженер ахлах дэслэгч Э.Баттөр, "Тэргүүний ахлагч"-аар инженер сапёрын ротын ахлагч-машинны дарга ахлах ахлагч Э.Батдалай, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар Үйлдвэрлэл

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 311 ДҮГЭЭР АНГИ



Баян-Өлгий аймгийн оны шилдгүүдэд шагнал гардуулах ёслолын ажиллагаа болж өндөрлөлөө. 2022 оны "Шилдэг төрийн байгууллага"-аар Зэвсэгт хүчний 331 дүгээр анги, Уулын тусгай батальоны хамт олон шалгарлаа.

Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа С.Бат-Эрдэнэ, Ажиллагааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа Ц.Алтанхүү, ангийн ахлагч, сургагч ахлагч Б.Баднаанямбуу

нар ангийн индэрт гарч оны шилдэг байгууллагын шагналаа гардан авсан бөгөөд энэ үеэр ангийн бие бүрэлдэхүүн хүрэлцэн ирж, баяр хүргэлээ.

Зэвсэгт хүчний 331 дүгээр анги нь Баян-Өлгий аймгийн 2022 оны "Шилдэг төрийн байгууллага", мөн "Зэвсэгт хүчний тэргүүний анги"-аар шалгарсан олон амжилтын буухиатай шинэ оноо угтаж байна.

Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №48

ДА ҮСЭГ БҮХИЙ УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА
ДА дэвсгэр бүхий, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, хичээнгүй сайхан бичиж, кириллээр хөрвүүлээрэй.
Дармал, бичмэл тигээр:

